

**БАГАНУУР – ЧОЙР ЧИГЛЭЛИЙН 188 КМ УРТ 220 КВ-ЫН  
2 ХЭЛХЭЭТ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ,  
ДЭД СТАНЦЫН ӨРГӨТГӨХ ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААР**

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, экспорт, импортын гол бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлтийн урсгал Өмнөговь, Дорноговь аймгийн нутгаар дайрдаг. Иймээс энэ бүс нутгийг цахилгаан эрчим хүч /цаашид “ЦЭХ” гэх/-ний найдвартай хангамж, 2 талын тэжээлийн эх үүсгүүртэй болгож, дамжуулах сүлжээний тойрог схем үүсгэх зайлшгүй шаардлагатай юм.

Энэхүү Багануур – Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам /цаашид “ЦДАШ” гэх/, 220/110/35 кВ-ын “Багануур”, “Чойр” дэд станцуудын өргөтгөлийн төсөл хэрэгжсэнээр Дорноговь, Дундговь, Хэнтий, Өмнөговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын 70,740 айл өрх, 46,261 аж ахуйн нэгж, 114 уул уурхай болон тухайн бүс нутгийн нийт 355,640 хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний чанар, найдвартай ажиллагаа, тогтвортой байдал хангагдахаас гадна Багануур – Чойр чиглэлийн 1 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ-ын дамжуулах чадвар нэмэгдэж, өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах боломжийг бүрдүүлнэ.

Өнөөгийн байдлаар “Багануур – Чойр – Айраг – Сайншанд – Замын-Үүд”, “Багануур – Улаанбаатар” чиглэлд 110 кВ-ын 1 хэлхээт ЦДАШ-аар дамжуулан ЦЭХ-ний хэрэглээг хангадаг бөгөөд болзошгүй байдлаар тасралт саатал, гэмтэл гарсан үед дээр дурдсан тооны хэрэглэгчид ЦЭХ-ээр шууд тасалдах эрсдэлтэй юм. Гэтэл энэ бүс нутагт ашигт малтмалын бүх том ордууд төвлөрч, ЦЭХ-ний хэрэглээ 500-600 МВт байгаа бөгөөд ойрын ирээдүйд энэ хэрэглээ 800-900 МВт хүртэл өсөхөөр байна.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр Сайншанд дахь Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэсэн ЦЭХ-ийг төвийн эрчим хүчний системд нийлүүлэх боломж бүрдэх юм. Тухайлбал Өмнөговь аймгийн Ханбогд суманд “Клинтек” компанийн хэрэгжүүлж буй 250 МВт-ын салхин цахилгаан станц, Говьсүмбэр аймаг Чойрт “Сан степпе” компанийн хэрэгжүүлэх 50 МВт-ын нарны цахилгаан станц, Дундговь аймаг Мандалговьд байрлах 30 МВт-ын нарны цахилгаан станц, Дорноговь аймаг Эрдэнэ суманд хэрэгжих 30 МВтын нарны цахилгаан станц тус тус болно.

Түүнчлэн, “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК-ийн хувийн хөрөнгө оруулалтаар “Бөөрөлжүүт”-ийн 600 МВт-ын дулааны цахилгаан станц барих төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тус станцын үйлдвэрлэсэн эрчим хүчийг энэхүү Багануур – Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ-аар дамжуулан төвийн эрчим хүчний системд нийлүүлэх боломж бүрдэх юм.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Чойр – Сайншанд, Сайншанд – Цагаансуварга, Багануур – Налайх – Улаанбаатар, Багануур – Чингис – Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ, дэд станцууд барих төслүүд хэрэгжихтэй холбогдуулан энэхүү Багануур – Чойр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 188 км урт ЦДАШ-ын дамжуулах чадварыг нэмэгдүүлээгүй, өргөтгөөгүй нөхцөлд дээр дурдсан

500-600 МВт-ын чадлыг дамжуулах боломжгүй тул уг төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт чухал ач холбогдолтой Улаанбаатар төмөр зам, Замын-Үүдийн төмөр замын боомт, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай нь тус ЦДАШ-аар дамжуулан ЦЭХ-ээр хангагддаг бөгөөд ЦЭХ-гүй болсон тохиолдолд Монгол Улсын хэмжээнд нийгэм, эдийн засгийн маш том хохирол үүсдэг. Үүнд:

1. Замын-Үүд боомтын үйл ажиллагаа доголдож, ачаа тээвэр бүрэн зогсоно;
2. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг том хотуудыг нүүрсээр хангадаг Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үйл ажиллагаа доголдож, дулааны 2, 3, 4 дүгээр цахилгаан станцууд зогсох, доголдох, өвлийн улиралд Улаанбаатар хот хөлдөх эрсдэлтэй;
3. Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд "Оюутолгой" уурхайг ЦЭХ-ээр хангах гэрээг 2021 онд байгуулсан. Уг гэрээний Монгол Улсын эрчим хүчний салбарын хариуцах хэсэгт техникийн найдвартай ажиллагааг хангахын тулд 207 дугаар ЦДАШ-ыг давхар хэлхээ болгох шаардлагатай бөгөөд уг шугамаар Оюутолгой уурхайг ЦЭХ-ээр хангах нэг талын тэжээл болох юм. Үүний үр дүнд жил бүр 100-120 сая ам.доллар Оюутолгой уурхайг ЦЭХ-ээр тэжээхэд БНХАУ-д төлж буй мөнгөн урсгал, валют дотооддоо үлдэх боломж бүрдэх юм;
4. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, экспорт, импортын гол бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлтийн урсгал Өмнөговь, Дорноговь аймгийн нутгаар дайрдаг. Иймээс энэ бүс нутгийн ЦЭХ-ний найдвартай хангамж, 2 талын тэжээл үүсгүүртэй болгох, дамжуулах сүлжээний тойрог схем үүсгэх нь зайлшгүй шаардлагатай. Тухайлбал өнөөгийн байдлаар Чойр-Айраг-Сайншанд-Замын-Үүд, Багануур-Улаанбаатар чиглэлд 110 кВ-ын нэг хэлхээт ЦДАШ-аар нийт хэрэглээг хангаж байна. Гэтэл энэ бүс нутагт ашигт малтмалын бүх том ордууд төвлөрч байгаа бөгөөд цахилгааны эрчим хүчний хэрэглээ 500-600 МВт байна. Ойрын ирээдүйд энэ хэрэглээ 800-900 МВт хүртэл өснө. Иймээс уг хэрэглээг хангахын тулд Багануур 700 МВт, Бөөрөлжүүт, Чандгана зэрэг ДЦС-ын төсөл, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний хэд хэдэн төслийг хэрэгжүүлнэ /сэргээгдэх эрчим хүчний хэд хэдэн төсөл амжилттай хэрэгжсэн/. Мөн Чойр-Сайншандын 220 кВ-ын ЦДАШ, дэд станцын төсөл хэрэгжиж эхлээд байгаа бөгөөд 2024 оны түвшинд бүрэн ашиглалтад орно. Ийм нөхцөлд Багануур-Чойр 220 кВ-ын ЦДАШ-ын дамжуулах чадварыг нэмэгдүүлээгүй, өргөтгөөгүй нөхцөлд дээр дурдсан 500-600 МВт чадлыг дамжуулах боломжгүй тул зайлшгүй энэ төслийг хэрэгжүүлэх шаардлагатай;
5. Говийн бүсэд баригдсан Цэций /50 МВт/, Сайншанд /55 МВт/ салхин цахилгаан станц, Нарантээг /15 МВт/, Говь /30 МВт/, Сүмбэр /10 МВт/ нарны цахилгаан станцууд өнөөгийн нэг хэлхээт 220 болон 110 кВ-ын ЦДАШ-ын улмаас бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжгүй байгаа бөгөөд 207 дугаар ЦДАШ давхар хэлхээтэй болсноор бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгальд орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл 30-50 хувь өсөх боломж бүрдэнэ;

6. Төсөл хэрэгжсэнээр Эрчим хүчний шинэ эх үүсвэр, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ. Сэргээдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд Багануур – Чойр, Чойр – Сайншанд, Сайншанд – Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын ЦДАШ-ын төслүүдийг барьж байгуулан дамжуулах сүлжээний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Түүнчлэн, Чойр – Сайншанд – Замын-үүд 110 кВ-ын ЦДАШ-ын дамжуулах чадвар хүрэлцэхгүй байгаа шалтгааны улмаас чадлыг хязгаарлах автомат тавьсан бөгөөд 110 кВ-ын Сайншанд ЦДАШ-аар 50 МВт-аас дээш чадал дамжсан нөхцөлд “Говь” нарны цахилгаан станцын үйлдвэрлэх чадлыг хязгаарласан байдалтай ажиллаж байна. Энэ нь сэргээгдэх эрчим хүчний байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дамжуулах шугамын хүчин чадлаас шалтгаалан хориглож буй үйлдэл болж байна.

---o0o---